

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/147/НА-СТА-ТӨҮГ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

ААС. 02.25 № 01/09
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд удирдах 3, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх 8, төрийн үйлчилгээний гүйцэтгэх 3, гэрээт буюу туслах чиг үүргийн 4 албан тушаалтан, улс төрийн буюу багийн Засаг дарга 4, нийт 22 орон тоотой батлагдсанаас гүйцэтгэх 2 ажилтан хавсран гүйцэтгэж нийт 20 орон тоотой ажилласан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Өндөрширээт суманд тохиолдсон цас зуд, байгалийн давагдашгүй хүчин зүйлд зориулж иргэдээс хандиваар 18,335.9 мянган төгрөг, Улсын онцгой комиссоос 106,900.0 мянган төгрөгийн Jimny маркийн суудлын авто машин, ковш 30, Дук машин 98,400.0 мянган төгрөг, аж ахуй нэгж байгууллагаас 9,955.0 мянган төгрөгийн шатахуун, 138,250.2 мянган төгрөгийн хүнс, хивэг, улаан буудай, малын тэжээл, 8,140.0 мянган төгрөгийг 100 толгой мал амьтад нийт 379,981.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө болон бараа материал ирүүлснийг бүртгэлд тусган тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 95,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,853,538.39	230,695,342.83
33	АВЛАГА	45,000.00	45,000.00
335	Бусад авлага	45,000.00	45,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	45,000.00	45,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	174,808,538.39	230,650,342.83
351	Түүхий эд материал	15,443,250.00	25,243,250.00
35110	Тусгай зориулалттай материал	15,443,250.00	25,243,250.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,725,000.00	30,694,000.00
354	Хангамжийн материал	66,420,288.39	101,473,092.83
35410	Бичиг хэргийн материал	2,185,100.00	5,045,100.00
35420	Аж ахуйн материал	27,475,903.90	60,323,903.90
35430	Сэлбэг хэрэгсэл	21,095,000.00	21,095,000.00
35440	Түлш, шатах тослох материал	655,200.05	4.49
35450	Барилгын засварын материал	3,345,000.00	3,345,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,664,084.44	11,664,084.44
35500	Биологийн хөрөнгө	7,720,000.00	7,720,000.00
35600	Мал амьтад	74,500,000.00	65,520,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,270,772,344.56	2,146,339,715.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,270,772,344.56	2,146,339,715.91
392	Биет хөрөнгө	1,254,174,324.56	1,958,709,695.91
39201	Барилга, байгууламж орон сууц	1,063,858,579.00	1,662,488,716.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(213,829,004.05)	(276,848,432.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	345,172,835.00	550,472,835.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(174,105,401.36)	(212,460,227.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,144,350.00	136,063,350.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,010,620.80)	(73,037,195.75)
39207	Тавилга, ажахуйн эд хогшил	17,730,542.30	21,230,542.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,611,121.50)	(13,712,499.15)
39209	Зам, гүүрийн байгууламж	98,756,054.00	98,756,054.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(20,878,667.80)	(20,878,667.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	255,357,192.00	261,957,192.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(158,410,412.23)	(175,321,970.92)
393	Биет бус хөрөнгө	16,598,020.00	187,630,020.00
39301	Програм хангамж	2,135,100.00	22,135,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,549,080.00)	(1,549,080.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,012,000.00	167,044,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,445,625,882.95	2,377,035,058.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	26,966.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	26,966.38
413	Өглөг	-	26,966.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	26,966.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,445,625,882.90	2,377,008,092.31
51	Засгийн газрын хувь оролцоо	1,445,625,882.90	2,377,008,092.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	425,137,525.38	425,137,525.38
51101	Өмч: - төрийн	425,137,525.38	425,137,525.38
512	Хуримтлагдсан үр дүн	822,976,700.39	1,754,358,909.80
51210	Өмнөх үеийн үр дүн	822,976,700.39	822,976,700.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	931,382,209.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,511,657.13	197,511,657.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,445,625,882.90	2,377,035,058.69

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,126,782,602.19	2,377,362,805.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	320,243,123.00	1,060,761,062.00
120	Нийтлэг татварын бус орлого	320,243,123.00	1,060,761,062.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	320,243,123.00	1,060,761,062.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	320,243,123.00	1,060,761,062.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,539,479.19	1,316,601,743.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,047,079.19	330,408,243.69
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,820,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	130,685,443.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,648,809.00	125,336,406.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,398,270.19	58,566,394.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	722,492,400.00	786,193,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	722,492,400.00	786,193,500.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутгийн төсөв/	-	200,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	-	200,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	843,130,511.60	1,445,980,596.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	802,768,270.60	1,264,901,569.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,190,809.98	1,132,113,656.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,354,873.59	583,310,400.97
210101	Үндсэн цалин	260,181,019.50	329,971,850.08
210102	Нэмэгдэл	101,102,241.78	234,070,313.40
210104	Урамшуулал	14,643,192.40	15,595,280.29
210105	Гэрээт ажлын хөлс	5,428,419.91	3,672,957.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,071,778.30	72,177,567.83
210201	Тэтгэврийн даатгал	32,222,466.20	49,832,748.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,813,548.75	5,796,772.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,243,537.35	2,895,086.31
210204	Ажилгүйдлийн даатгал	695,634.99	2,703,739.46
210205	Эрүүл мэндийн даатгал	7,096,591.01	10,949,220.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,818,787.68	33,836,753.53
210301	Гэрэл, цахилгаан	4,890,787.68	6,908,753.53
210302	Түлш, халаалт	26,928,000.00	26,928,000.00
2104	Хангамж бараа материалын зардал	48,090,257.00	136,348,127.16
210401	Бичиг хэрэг	5,155,550.00	2,327,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,493,677.00	50,676,384.31
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,775,000.00	5,382,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,486,030.00	77,962,242.85

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,928,900.00	14,547,000.00
210604	Урсгал засвар	1,928,900.00	14,547,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,318,000.00	12,444,000.00
210702	Дотоод албан томилолт	4,318,000.00	12,444,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,678,255.00	7,287,331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,612,005.00	5,316,544.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	253,200.00	231,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,050.00	731,667.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,929,958.41	272,162,475.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,825,486.00	135,748,710.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,104,472.41	136,413,765.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,577,460.62	132,787,913.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,488,280.00	37,161,741.51
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,658,280.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,815,482.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	29,346,259.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,089,180.62	95,626,171.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,089,180.62	95,626,171.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,362,241.00	181,079,026.90
2200	Дотоод эх үүсвэрээр	40,362,241.00	181,079,026.90
221001	Их засвар	-	72,966,576.00
222001	Тоног төхөөрөмж	40,362,241.00	-
223001	Бусад хөрөнгө	-	108,112,450.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	283,652,090.59	931,382,209.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	283,652,090.59	931,382,209.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	806,539,479.19	1,316,601,743.69
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,539,479.19	1,316,601,743.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,047,079.19	330,408,243.69
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,820,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	130,685,443.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,648,809.00	125,336,406.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,398,270.19	58,566,394.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	722,492,400.00	986,193,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	722,492,400.00	786,193,500.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутгийн төсөв/	-	200,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	676,508,483.19	1,004,478,767.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,508,483.19	1,004,478,767.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,231,022.57	871,690,854.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,354,873.59	583,310,400.98
210101	Үндсэн цалин	260,181,019.50	329,971,850.08
210102	Нэмэгдэл	101,102,241.78	234,070,313.40
210104	Урамшуулал	14,643,192.40	15,595,280.29
210105	Гэрээт ажлын хөлс	5,428,419.91	3,672,957.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,071,778.30	72,150,601.45
210201	Тэтгэврийн даатгал	32,222,466.20	49,805,782.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,813,548.75	5,796,772.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,243,537.35	2,895,086.31
210204	Ажилгүйдлийн даатгал	695,634.99	2,703,739.46
210205	Эрүүл мэндийн даатгал	7,096,591.01	10,949,220.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,818,787.68	33,836,753.53
210301	Гэрэл, цахилгаан	4,890,787.68	6,908,753.53
210302	Түлш, халаалт	26,928,000.00	26,928,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,573,400.00	41,517,442.70
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,618,400.00	33,669,942.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,775,000.00	5,197,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	300,000.00

2105	Нормативт зардал	-	850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,279,900.00	21,544,000.00
210604	Урсгал засвар	2,279,900.00	21,544,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,318,000.00	12,444,000.00
210702	Дотоод албан томилолт	4,318,000.00	12,444,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,124,505.00	12,139,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,058,255.00	10,168,939.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	253,200.00	231,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,050.00	621,667.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,689,778.00	93,897,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,689,778.00	93,897,930.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,277,460.62	132,787,913.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,188,280.00	37,161,741.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,358,280.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,815,482.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	29,346,259.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,089,180.62	95,626,171.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,089,180.62	95,626,171.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	130,030,996.00	312,122,975.80
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	130,030,996.00	312,122,975.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,030,996.00	312,122,975.80
2200	Дотоод эх үүсвэрээр	130,030,996.00	312,122,975.80
221001	Их засвар	-	82,766,576.00
222001	Тоног төхөөрөмж	53,240,996.00	-
223001	Бусад хөрөнгө	-	126,791,132.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	76,790,000.00	102,565,267.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	207,420,800.23	148,903,731.94	781,462,057.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,137,525.38	207,420,800.23	148,903,731.94	781,462,057.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,863,185.23	-5,863,185.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	822,976,700.39	1,445,625,882.90
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	822,976,700.39	1,445,625,882.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	822,976,700.39	1,445,625,882.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	931,382,209.41	931,382,209.41
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	1,754,358,909.80	2,377,008,092.31

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 2,835,042.2 мянган төгрөгийн зөрчлөөс 4,790.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,694.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,156,387.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,060,761.1 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө, бараа материалаар салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 95,626.2 мянган төгрөгийг тохируулга хийж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 2,835,042.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,790.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 8,619.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 2,821,632.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Ахмадын холбоонд гольфийн иж бүрдэл болох бөмбөг, цохиур авахад нийт 600.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “Хулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Төрийн албаны өдрийн үйл ажиллагааны зардалд 1,256.2 мянган төгрөгөөр гарын бэлэг болон хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 4 албан хаагчид 29,346.3 мянган төгрөг олгосон байна. Дээрх урамшууллаас ХХОАТ 2,934.6 мянган төгрөгийг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсхүл төвлөрүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд Улсын заан Д.Хүдэрбулга-д хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны зардалд 2,639.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Тус байгууллага тайлант онд Чанар бүтээмж төв хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 5,980.0 мянган төгрөгөөр ИТХ-ын нарийн бичгийн даргыг Турк улс руу туршлага солилцох хөтөлбөрт зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд 27.0 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд 45.0 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь 5,169.3 мянган мкв талбайтай 17 газартай ба нийт 2,821,560.4 мянган төгрөгийн дүнтэй газруудаа орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй, нэгж талбар, дүн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах тухай аргачлал”-ыг гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид биет бус хөрөнгө болох газрыг бүрэн гүйцэт орлогод авч, нэгжийн талбар болон дүн зөрүүтэй зөрчлийг арилгах.

4. Бараа материал данстай холбоотой асуудал

Бараа материалын тодруулга тайланд цас зудтай холбоотой бараа материалыг бэлэн бүтээгдэхүүн гэж буруу дансны ангилал сонгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид УСНББОУС-г дагуу тайлан бэлтгэж, дансны ангилал зөв сонгох.

5. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Шилэн дансанд мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл огт мэдээлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох

бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шилэн дансны зарчим”-ыг гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын холбоонд гольфийн иж бүрдэл болох бөмбөг, цохиур авахад нийт 600.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	600.0	1	600.0				
Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 4 албан хаагчид 29,346.3 мянган төгрөг олгосон байна. Дээрх урамшууллаас ХХОАТ 2,934.6 мянган төгрөгийг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.	1	2,934.6	1	2,934.6				
Бэлэг, дурсгалын зүйл болон хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан	1	1,256.2	1	1,256.2				
Д.Хүдэрбулга-д хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны зардалд 2,639.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан байна.	1	2,639.0			1	2,639.0		
Чанар бүтээмж төв хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 5,980.0 мянган төгрөгөөр ИТХ-ын нарийн бичгийн даргыг Турк улс руу туршлага солилцох хөтөлбөрөөр аялуулсан байна.	1	5,980.0			1	5,980.0		
Тус байгууллага нь 5,169.3 мянган мкв талбайтай 17 газартай ба нийт 2,821,560.4 мянган төгрөгийн дүнтэй газруудаа орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй, нэгж талбар, дүн зөрүүтэй байна.	1	2,821,560.4					1	2,821,560.4
Тус байгууллага нь тайлант онд 45.0 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага үүсгэсэн байна.	1	45.0					1	45.0
Тус байгууллага нь тайлант онд 27.0 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой өглөг үүсгэсэн байна.	1	27.0					1	27.0
Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл огт мэдээлээгүй байна.	1	0					1	0

Бараа материалын тодруулга тайланд цас зудтай холбоотой бараа материалыг бэлэн бүтээгдэхүүн гэж буруу дансны ангилал сонгосон байна.	1	30,694.0					1	30,694.0
Дүн	9	2,865,736.2	3	4,790.8	2	8,619.0	4	2,852,326.4

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn